**БАТЛАВ.**
УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
.....Ц.АМАРСАНАА

# ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2025.12.05 Дугаар № Ш04/2025 Улаанбаатар хот

| | |
|---|---|
| ***1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг:*** | Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК, /Дулааны шугамын нөхцөл/<br>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, төв байр |
| ***2. Барилгын байршил, мэдээлэл:*** | Амгалан дулааны станцын хажуу талд шинээр төлөвлөж буй дулааны эх үүсвэрээс 6д магистрал шугам хүртэл шинээр татах 2Ф800/700/600мм-н голчтой дулааны шугам. |
| ***3. Холбогдох цэг, байршлын зураг, схем:*** | Амгалан дулааны станцын хажуу талд шинээр төлөвлөж буй дулааны эх үүсвэрээс 6д магистрал шугам хүртэл шинээр татах 2Ф800/700/600мм-н голчтой дулааны шугам.<br><br>Сүлжээний даралт, температурын утга:<br>- Холболтын цэг дээр байх түрэлт 60.0 м.у.б<br>- Шугамын статик даралт 18.0 м.у.б<br>- Буцах шугамын даралт 2.0 ата<br>- Гадна агаарын тооцоот температур -39°C<br>- Температурын график 150/70°C |
| ***4. Дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, хэрэглээ*** | 2Ф800мм, 2Ф700мм, 2Ф600мм |
| ***5. Дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ, дулаан дамжуулах төвийг өргөтгөх, тоноглолд тавигдах шаардлага:*** | 5.1. Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах шугам хоолой, тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх ба ОХУ-ын ГОСТ-Ст-20, БНХАУ-ын GB-20G, АНУ-ын AISI-G1020 болон үүнтэй дүйцэхүйц маркийн байна. Шугам хоолойн ханын зузаан Ду-820-10 мм-ээс багагүй, Ду-720-10 мм-ээс багагүй, Ду-630-10 мм-ээс багагүй, үйлдвэрийн цутгамал оёдолгүй эсвэл шулуун оёдолтой хоолой байна. Шугам хоолойн булан /отвод/ нь үйлдвэрийн цутгамал байх бөгөөд түүний хана нь шугамын ханын зузаантай ижил хэмжээтэй урьдчилсан дулаалгатай шугам төлөвлөх<br>5.2 Шинээр татах 2Ф800мм голчтой дулааны шугамыг хотын зүүн хэсгийн сүлжээг хангаж байгаа Амгалан дулааны станцын 2Ф900мм голчтой коллектор шугамтай холбох “Холбоос шугам”-ыг зураг төсөлд тусгах. |

5.3 УБДС ТӨХК-ийн №1-9/2024-8 дугаартай дулаан хангамжийн тоноглолын техникийн тодорхойлолтыг мөрдөх.

***6. Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага:***

6.1. Дулааны эрчим хүчний тооцоонд "Хэмжил зүйн тухай хууль"-ийн 9, 10 дугаар зүйлийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилт, улсын баталгаажуулалтад хамрагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн, дулааны тоолуурын лабораториор шалгагдсан, баталгаажуулалтын гэрчилгээ бүхий тооцооны хэмжих, тооцох хэрэгслийг суурилуулна.

6.2. "Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм"-ийн 6 дугаар бүлэгт заасны дагуу хангагч "Улаанбаатарын дулааны сүлжээ" ТӨХК-иас дулааны эрчим хүчийг хэмжих тооцох хэрэгслийг суурилуулах техникийн нөхцөл авах.

6.3. Дулааны эрчим хүчний тооцооны болон хяналтын хэмжих хэрэгслийг "Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм"-ийн шаардлагын дагуу иж бүрнээр суурилуулна.

***7. Зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага:***

7.1. Шугамын трассын дагуу геодези, хөрсний усны дүгнэлт гаргуулж, хөрсний устай нөхцөлд хөрсний усны түвшинээс дээш байхаар шугамын түвшинг сонгох. Хэрэв хөрсний усны түвшинд шугам сүлжээг байрлуулахаар бол шугамын сувгийг хөрсний ус нэвчихгүй байдлаар хамгаалалтуудыг зураг төсөлд нэмэлтээр тусгаж өгөх.

7.2 Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 2.2-т заасан дамжуулах төв, дулааны шугамын хамгаалалтын зайг мөрдөн, барилга байгууламжийг төлөвлөх, мөн дүрмийн 2.6, эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасны дагуу хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, гэр хашаа барих, барилгын тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

7.3. Дулааны шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

7.4. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох явцад трассын дагуух зам талбай, ногоон байгууламжийг сэргээх, тохижилт хийх болон дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.

7.5. Гадна дулааны шугам хоолой болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм норматив нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

7.6. Дулааны шугам сүлжээ авто зам доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөн, зураг төсөвт тусгах.

***8. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам:***

8.1. Дулааны шугам сүлжээ, тоноглолын зураг, төсөв боловсруулах, барилга угсралт, туршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад дараах хууль, дүрэм, журам, барилгын норм ба дүрэм, стандартуудыг мөрдөж ажиллана.

8.1.1. Эрчим хүчний тухай хууль
8.1.2. Барилгын тухай хууль
8.1.3. Хэмжил зүйн тухай хууль
8.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"
8.1.5. Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаал баталсан "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм"
8.1.6. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тушаалаар баталсан "Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"
8.1.7. Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар баталсан "Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"
8.1.8. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолоор баталсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"
8.1.9. Барилгын норм ба дүрмүүд
8.2. Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Эрчим хүчний дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна", мөн хуулийн 30.1.13-т "нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх" гэж заасны дагуу хангагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх нөхцөл хангасан тохиолдолд дулааны эрчим хүчээр хангана.
8.3. Эрчим хүчний тухай хуулийн 29.1.9-д "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй" гэж заасан, мөн хэрэглэгч нь хуулийн 30.1.10-т "түгээх, зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах" гэж заасны дагуу өөр хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй.
8.4. "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм" дагуу дулааны шугам сүлжээ, дулаан дамжуулах төвийн зураг төсөл, төсвийг боловсруулах, барилга угсралт, туршилт, тохируулгын ажлыг Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл"-тэй эрх бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх.

***9. Техникийн нөхцөл олгосон үндэслэл:***

"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирал нарт хамтран ажиллах, техникийн эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүрэг даалгавар, чиглэл өгсөн Эрчим хүчний сайдын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн а/1251 дугаартай, 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн а/1821 дугаартай бичгүүдийг үндэслэв.

| | |
|---|---|
| ***10. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа:*** | 10.1. Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд буюу 2027 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хүчинтэй.<br>10.2. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ. |
| ***11. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох:*** | 11.1. Дараах тохиолдолд энэхүү техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:<br>11.1.1. Хүчинтэй хугацаа дуусан;<br>11.1.2. Энэхүү техникийн нөхцөлийн аль нэг заалт, шаардлагыг биелүүлээгүй;<br>11.1.3. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;<br>11.1.4. Олгосон ачааллаас хэтрүүлэн чадал ашигласан, мөн холболтын цэгийг өөрчилсөн тохиолдолд;<br>11.2. Хугацаа дуусан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийг дулаанд холбохыг хориглоно. |

ЗӨВШӨӨРСӨН :
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ш.МӨНХЖАРГАЛ

ХЯНАСАН:
ҮБХ-ИЙН ДАРГА Г.БАЯРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
ҮБХ-ИЙН ИНЖЕНЕР Н.САНЖААЖАМЦ

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:**

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн шаардлагууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалттай танилцсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Нэр:..... Гарын үсэг: .....

Регистрийн дугаар: .....

Холбоо барих: .....

Огноо: